



2024 оны жилийн эцсийн Лүн багийн статистик тоон үзүүлэлт

Нийт хүн амын тоо
755

Нийт өрхийн тоо
226

Хүйсийн харьцаа




18 хүртэлх
281

55-аас дээш
108

Гэрт
105

Байшинд
121

НАС, ХҮЙСИЙН СУВАРГА



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



Түр оршин суугаа
3

Түр эзгүй
2



54.7
Хүүхдийн ачаалал

+



10.5
Хөгшидийн ачаалал

=



65.2
Хүн ам зүйн ачаалал




Хаягандаа амьдардаггүй
125



Гадаадад оршин суугч
4

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд айл өрхүүдээр анхааруулах, сэрэмжлүүлэг, өвөлд бэлтгэх өвс тэжээлийн хуваарийг өрх бүрээр гаргаж хүргүүлсэн



 ГОВЬСҮМБЭР АЙМАГ

 БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГИЙН

 ЗАХИРАМЯ

 2023 оны 12 сарын 21 өдөр

 Дугаар 4/20

 Баянтал сум

 Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Сумын 2023-2024 оны хөдөө аж ахуйн болон төв, суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулуулгай. Ажлын хэсгийн дарга Э.Эрхэмбаяр (Засаг даргын орлооч) Нарийн бичгийн дарга С.Оюунтулхүүр (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Гишүүд: Э.Түмэн-Эрдэнэ (Лун багийн Засаг дарга) Т.Ган-Эрдэнэ (Их Уул багийн Засаг дарга) Т.Эрдэнэбаяр (Хөдөө аж ахуйн мэргэжилтэн) Ч.Отгонцэцэг (Байгаль орчны мэргэжилтэн) Д.Цэрэнням (Ерөнхий боловсролын сургуулийн захирал) Б.Энхмэнд (Цэцэрлэгийн эрхлэгч) Э.Баасангарав (Эрүүл мэндийн төвийн даргын орлооч) Х.Энхжаргал (Совьёлын төвийн дарга) А.Батжаргал (Талын-ич) СОНААТГАГ зарын захирал

2. Сумын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталуулгай.

3. 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангуулах, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА: 



 БАГАНБАР

№	Малчны овог нэр	Багийн нэр	Нийт малын тоо	Малын төрөл					Нийт малыг бодод шилжүүлснээр	Нийт малыг бодод шилжүүлснээр	Нэмэгдэл тэжээлээр тэжээх мал (хонин толгойд шилжүүлснээр)	Өрх суурьт бэлтгэх											
				Тэмээ	Адуу	Ухар	Хонь	Ямаа				Өвс /тн/	Үйлдвэрийн тэжээл /тн/	Гар тэжээл/тн/	Хужир /тн/	Буудц /тн/							
1-р БАГ МАЛЧИН ӨРХ																							
1	Г.Мөнхбаяр	1	3181	152	245	2108	676	740	5250	890	80.1	20.0	4.0	0.8	78.8								
2	Б.Мянганбаяр	1	1298	8	21	412	783	74	578	2726	673	60.6	15.1	3.0	0.6	40.9							
3	Г.Баярмагнай	1	1290	2	153	19	687	429	475	2268	291	26.2	6.6	1.3	0.3	34.0							
4	Чимидцогзол Баттогтох	1	1235	161		666	408	323	1494	263	23.7	5.9	1.2	0.2	22.4								
5	Г.Эрдэнэсайхан	1	1086	54	10	480	542	256	1406	224	20.2	5.1	1.0	0.2	21.1								
6	С.Ганболд	1	1035		67	519	449	210	806	265	23.9	6.0	1.2	0.2	12.1								
7	Л.Мөнхбаатар	1	949	69		518	362	270	1327	193	17.4	4.3	0.9	0.2	19.9								
8	Б.Тойруул	1	902	70	15	519	298	209	848	200	18.0	4.5	0.9	0.2	12.7								
9	Д.Оюунбилэг	1	876		15	716	145	137	937	187	16.9	4.2	0.8	0.2	14.0								
10	Ж.Батсүрэн	1	832	64	108	543	117	277	1984	282	25.3	6.3	1.3	0.3	29.8								
11	Г.Ууганбат	1	761	23	428	300	109	836	167	15.0	3.8	0.8	0.2	12.5									
12	Л.Банди	1	751	27	45	389	290	173	1386	193	17.4	4.4	0.9	0.2	20.8								
13	С.Базарханд	1	656	23	1	400	232	142	776	131	11.8	2.9	0.6	0.1	11.6								
14	Ч.Пунцагдаш	1	647	44	15	424	164	150	1065	148	13.3	3.3	0.7	0.1	16.0								
15	Р.Манлайсүрэн	1	616	88	17	170	339	247	1193	146	13.2	3.3	0.7	0.1	17.9								
16	Б.Цэндбаяр	1	600	35	35	330	200	150	1154	156	14.1	3.5	0.7	0.1	17.3								
17	Ц.Хатанбаатар	1	585	26	7	262	290	132	747	122	11.0	2.7	0.5	0.1	11.2								
18	Л.Эрхэмбаяр	1	551	25	4	285	237	106	955	113	10.2	2.5	0.5	0.1	14.3								
19	Р.Баатарсүрэн	1	513	23	8	386	96	122	681	112	10.1	2.5	0.5	0.1	10.2								
20	Д.Нямцэрэн	1	585	7	11	382	185	105	671	125	11.3	2.8	0.6	0.1	10.1								

МАЛЧДЫН АНХААРЛД

- Эрүүл мэндийн байгууллагаас гарсан (Ковид-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг сайтар баримтлах.
- Өвөлжөө, хаваржааны ойролцоо ил задгай үнс, нурам асгахгүй байх, дулуу унтраасан цуцил, тамхины иш, машины яндан болон бусад төрлийн галын аюулаас сэрэмжлэх.
- Отор нүүдэл хийх, отор дамжин өнгөрөхөд мал эмнэлэгийн халдвар хамгааллын дэлгэмийг сайтар берьж ажиллах.
- Ил задгай хог хаягдал болон сэг, зэм хаяхгүй байх хаях шаардлага гарсан тохиолдолд зориулалтын цэгт хаях.
- Өвчний шинж тэмдэгтэй мал, амьтан илгэсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад гаралтай мэдэгдэх өөрийн малыг ойртуулахгүй байх.
- Өрхийн өвөлжилтийн бэлтгэлээ сайн базааж дулаан хувцас, түлш, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнээ нөөцлөх.
- Нийт малын 25 хувийг 90 хоног тэжээх өвс бэлтгэх, ногоон болон үйлдвэрийн тэжээл бэлтгэх, бууц нөөцлөх, хужир татах, малын гаралтай гар тэжээл бэлтгэхийг анхааруулж байна.
- Зайшгүй үед холбоо барих утас-ны жагсаалттай байх.

Сайн бэлтгээл өвөлд ажрахгүй.

БАЯНТАЛ СУМЫН МАЛЧДЫН АНХААРЛД

Хил залгаа Төв аймгийн Баянжаргалан, Дундговь аймгийн Баянжаргалан сумдад малын гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзан өвчний гаралт буурахгүй, тархалт нэмэгдэх зрсдэлтэй байгаа тул халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор:

- Хорио цээрийн дэглэм тогтоосон сумдын нутаг дэвсгэрээс малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний худалдаа, нийлүүлэлт, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх
- Мал эмнэлгийн угаалга, туулгалт, ариутгал халдваргүйжүүлэлтэд бүрэн хамрагдах
- Зөвшөөрөлгүй ил задгай, гэрийн нэхцөлд "Мал эмнэлгийн гэрчилгээгүй малын мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг худалдаалахгүй байх" зөвлөмжийг хүргүүлж байна.


БАЯНТАЛ СУМЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ



ЦАС ХАГАЛЖ ЗАМ ГАРГАХ ЗОРИУЛАЛТАЙ ДАЛЬПУУ ХИЙСЭН



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 011-Р АНГИАС ТУУЛАХ ЧАДВАР САЙТАЙ ЗИЛ-131 АВТОМАШИНЫГ СУМЫН ОНЦГОЙ КОМИСС ТҮР ХУГАЦААНД АВЛАА


ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Нутгийн удирдлагын ордон, 1 дүгээр баг,
Баянтал сум, Говьсүмбэр аймаг, 42043
Цахим шуудан: bayantal.ith@gmail.com


2023.12.19 № 72


танай _____-ны № _____-г

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 011-Р АНГИЙН
ЗАХИРАГЧ, ХУРАНДАА М.БАТДОРЖ ТАНАА


Говьсүмбэр аймгийн Баянтал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас танай байгууллагатай хамтарч ажиллах талаар дараах хүсэлтийг хүргүүлж байна.

Сумын нийт нутгаар 2023 оны 10 дугаар сараас эхлэн олон удаагийн давтамжтай их хэмжээний цас орж, шуурч, хатуурсан тул өвөлжилтийн нөхцөл байдал нэн хүнд болж, зам харгуй хаагдаж, мал бэлчээрлэх боломжгүй болсон тул туулах чадвар сайтай автомашин 2ш 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд ашиглуулж, хамтарч ажиллана уу.


ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ







Баянтал сумын малын хорогдолын мэдээ



Баянтал сумын хэмжээнд өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой гарсан зардлууд

№	утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн	Тайлбар
1	Дальпуу чирсэн ДЗ түлш	л	600	3800	2,280,00.00	3,998.6 мянган төгрөгийн зардлыг ОНХС-ийн гамшгийн зардлаас зарцуулсан байна./Сумын ЗД-ын 2024.02.01-ний өдрийн А/22 дугаар захирамж/
	Дальпуу чирсэн шатахуун	л	661	2600	1,718,600.00	
2	Өвс	боодол	356	20,000	7,120,000.00	Сумын ЗД-ын 2024.02.27-ны өдрийн А/29 дугаар захирамж болон Баянтал сумын ЗДЗ-ийн 2024.02.27-ны 03 дугаар тэмдэглэлийг үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган зарцуулсан байна.
3	Өвс /татсан шатахууны зардал	л	100	3900	390,000.00	ЗДТГ-ын багийн шатахууны зардлаас шилжүүлсэн байна.
4	Сэг зэм устгал ажлын томилолт	ш	187	30000	5,610,000.00	Одоогоор энэ томилолтын зардлыг олгоогүй өглөг үүсгэсэн байна.
5	Хөлсөөр ажилласан ковш	ш	1	15,000,000.00	15,000,000.00	3 цэг 6 нүх ухуулж, булшлсаны ажлын хөлсийг 4.30-нд төлөхөөр гэрээ байгуулж өглөгтэй байна.
6	Хөлсөөр ажилласан ковшийн ажлын хөлс	ш	1	4,340,000.00	4,340,000.00	Сумын ОНХС-ийн гамшгийн зардлаас сэг зэм устгах зардлаас зарцуулсан. /Сумын ЗД-ын 2024.02.27-ны өдрийн А/29 дугаар захирамж болон Баянтал сумын ЗДЗ-ийн 2024.01.27-ны 02 дугаар тэмдэглэлийг үндэслэн ОНХС-ийн гамшгийн зардлын сэг зэм устгалын зардлаас гаргаж зарцуулсан байна.
7	Сэг зэмд ажилласан хүмүүст халдвар хамгааллын хувцас	ш	1	1,500,000.00	1,500,000.00	
8	Сэг зэмийг булшлах, бөөгнүүлэх, сэг зэм устгах нүх ухах шатахууны зардал	л	2133	3800	8,105,400.00	НЭБУ ххк-д 8105.4 мянган төгрөгийн шатахууны өртэй байна. Үүнийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан болно.
9	Хоолны зардал	ш	1	650.0	650,000.00	Сэг зэм устгалд ажиллаж байгаа хүмүүсд хоол хийж өгсөн хоолны материалын мөнгө /зээлээр авсан./
Дальпуу чирсэн болон сэг зэм устгалын зардлуудын нийт дүн					46,714,000	

Сумын онцгой комиссид ирсэн мөнгөн хандивын мэдээлэлийн талаар

2024.01 дүгээр сарын 10-аас -2024.02 дугаар сарын 19-ны хооронд 7 төсвийн байгууллага, 1 ОНӨААТҮГ нийт 3,140.0 мянган төгрөгийн хандив, 2024 оны 02 дугаар сарын 20-оос 2024 оны 3 дугаар сарын-03-ныг хүртэл сумын 4 иргэн 400.0 мянган төгрөг , ахмад настнуудаас 400.0 мянган төгрөг, ЕБСургуулийн хүүхдүүдээс 603.9 мянган төгрөг, Монэколл ххк-нээс 10,000.0 мянган төгрөг, хандиваар цугласан бүгд дүн 14,543.9 мянган төгрөгийн хандив орж ирсэн байна. Үүнээс 93 малчин өрхдөө сумын онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 03 дугаар шийдвэрээр 1 айлд 13 л шатахуун олгосон Нийт 3,143.4 мянган төгрөг зарлага гарч хандивын үлдэгдэл 11,400.5 мянган төгрөг байсныг Аймгийн ЗДТГ-ын 2024.03.20-ны өдрийн Б/107 дугаар албан тоотоор Аймгийн ЗДТГ-ын нэмэлт дансруу шилжүүлсэн байна.

МАЛЧДАД ТУСЛАХ АЯН

ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭНТЭЙ ХОЛБОГДОН “МАЛЧДАД ТУСЛЪЯ” АЯНЫ ХҮРЭЭНД АЛБАН
БАЙГУУЛЛАГУУД НЭГЭН ДУУ ХООЛОЙГООР НЭГДЭЖ БҮГД ХАМРАГДАН МӨНГӨН
ХУРИМТЛАЛ

ЦЭЦЭРЛЭГ-420,000₮

ЭМТ-420,000₮

СТӨВ-150,000₮

ЕБС-780,000₮

ЗДТГ-630,000₮

ТАГНУУЛ-200,000 ₮

ТАЛЫН ИЛЧ-540,000₮ БОЛОН ХОЁР
МАЛЧИНД ТУС БҮР 2,5ТН НҮҮРСНИЙ
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН.

НИЙТ 3,140,000₮-ИЙГ 93 МАЛЧИН ӨРХӨД
ХУВААН ШАТАХУУН БАЙДЛААР
ОЛГОХООР
ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.

“ХАЛУУН СЭТГЭЛ”

МАЛЧДАДАА ТУСЛАХ АЯН

Баянтал суманд CARITAS MONGOLIA-н 2024/01/17-ны өдөр 10-н малчин өрхөд 2024/04/19-ны өдөр 15-н малчин өрхөд тус, тус хүмүүнлэгийн тусламж олгов.



Сумын онцгой комисс хуралдаж 8-н төсвийн байгууллага болон аж ахуй нэгжээс нийт цугларсан 3,140,000-ний мөнгөн тусламжийг 93-н малчин өрхөд шатахуун болгож нэг өрхөд 33,800 мянган төгрөгийн шатахуун олгож эхэлсэн байна.



**СУМЫН ЛҮН БАГИЙН ИРГЭН, АРВИЖИХ ДЭЛГҮҮРИЙН ЭЗЭН
Ё. НАНСАЛМАА НЭР БҮХИЙ ИРГЭНД 100,0 МЯНГАН ТӨГРӨГИЙН
ХҮНСНИЙ ТУСЛАМЖ, СУМЫН ОНЦГОЙ КОМИССТ 100,0 МЯНГАН ТӨГРӨГ,
НЭМНЭЭ, БЭЭЛИЙ ГЭХ МЭТ ЭД ЗҮЙЛСИЙН ХАНДИВ ӨРГӨЛӨӨ**



Лүн багийн иргэн О.Эрдэнэбүрэнгийн гэр бүл, С. Батмөнх, Б.Мөнхзул, Б.Зулбаяр нарын гэр бүлээс сумын онцгой комисст 200,0 мянган төгрөг, хүнсний зүйлсээр хандив өргөлөө



Сумын онцгой комисст эмийн сангийн хамт олноос эмийн багцын хандив өргөлөө.



Боржигин нутгийн малчин зон олондоо туслах "10.000 НЭМНЭЭ" хандивын аянд нэгдэж

1. Мөнгөн тусламж 780000,

2. Нэмнээ 52,

3. 100000 төгрөгийн хүнсний зүйл хандивлаж,

Малчин айлд очиж гэр, хорооны цасын цэвэрлэж өгч малчдадаа эд материалын болон сэтгэлийн дэм өгсөн



СУМЫН АХМАДЫН ХОЛБООНООС МАЛЧДАДАА ЗОРИУЛЖ 400,0 МЯНГАН ТӨГРӨГ, БЭЭЛИЙ, НЭМНЭЭ БУСАД ЭД ЗҮЙЛСИЙГ СУМЫН ОНЦГОЙ КОМИССТ ХАНДИВЛАЛАА.



СУМЫН "АВАРГА" ЗООГИЙН ГАЗРААС НЭР БҮХИЙ МАЛЧДАД 200,0 МЯНГАН ТӨГРӨГИЙН ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ХАНДИВЛАХААР БОЛЛОО



Лүн багийн иргэн Д. Батнасангийн гэр бүлээс сумын онцгой комисст 100,0 мянган төгрөгийн хандив өргөлөө



**"Оюут Боржигин" ХХК-наас 1 малчин өрхөд 150,0
мянган төгрөгийн малын тэжээл, хүнсний эд зүйлийн
хандив**



СУМЫН СУРГУУЛИЙН ДУУ ХӨГЖМИЙН БАГШ Л. ГАНТӨГСИЙН САНААЧЛАГААР
МАЛЧДАДАА ЗОРИУЛЖ " СЭТГЭЛИЙН ДЭМ" ХҮҮХДИЙН КОНЦЕРТИЙГ ЗОХИОН
БАЙГУУЛЖ НИЙТ 604400 ТӨГРӨГИЙГ СУМЫН ОНЦГОЙ КОМИССТ ӨГСӨН



Сумын аж ахуй нэгж, байгууллагууд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын / малчдадаа тусалъя / аяны хүрээнд ЗДТГ, 4-р сургуулийн ажилтан албан хаагчдын гэрт тусалцаж ажиллаа



Талын илч онѳаатуг-н нийт 2 малчин ѳрхѳд тус бѳрд нь 2,5 тн нѳѳрс олгосон байна



Дэлхийн зөн олон улсын байгууллагаас нийт 32 өрхөд 14,560,000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлсэн нэг өрхөд 455,000 төгрөгийг тухайн малчин өрхийн дансаар 2024 оны 02 дугаар сарын 24-ны өдөр хийсэн байна.

The logo for World Vision, featuring an orange triangle with a white starburst in the top right corner.

World Vision

Дэлхийн Зөн Монгол

Аймгийн онцгой комисс, Эрүүл мэндийн газраас ирүүлсэн дусал, эм тариа болон сумын эрүүл мэндийн төв өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан сэг зэм устгахтай холбоотой хамгаалалтын хувцас, бээлий, нүдний шил зэрэг 96 багцыг бэлтгэж малчдадаа хүргэж байна



СУМЫН ТӨВИЙН ДУЛААН ХАНГАМЖ



Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 6 худаг, цэвэр усны 750 м, бохир усны 1.42 км урт шугам хоолойтой.

Дулаан хангамж: Сумын төвд 1 төвлөрсөн уурын зуух, Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 9 жилийн 4 дүгээр сургууль, 4 дүгээр цэцэрлэг, Соёлын төв, “Талын Илч” ОНӨГазар зэрэг бүх байгууллагууд, айл, өрхийн орон сууц нэгдсэн дулаантай, цэвэр бохирын шугамд бүрэн холбогдсон.

Нүүрсний нөөц: 4 хоногийн нөөцтэй байна.

Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотой сумын ИТХ болон ЗДТГ-аас петроголд / ховилын нүүрсний уурхай /-д санал хүргүүлсний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд 40тн, талын илч ОНӨААТҮГ 20тн, нүүрсийг иргэдэд тараасан



Сумын онцгой комисс өвөлжилтийн цаг үеийн байдлаар цахимаар болон танхимаар комиссын хурлыг тогтмол явуулж байна





**Өвөлжилт хүндэрсэн сумдад малын тэжээл олгох
тухай Аймгийн засаг даргын захирамжийн дагуу
тэжээл татаж авлаа**



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ А/02 ДАГУУ СУМЫН ОНЦГОЙ КОМИСС
ХУРАЛДАЖ МАЛЧИН ӨРХӨД 10 БООДОЛ ӨВС, 2ШУУДАЙ ТЭЖЭЭЛ, МАЛ БҮХИЙ ӨРХӨД 5
БООДОЛ ӨВС 1 ШУУДАЙ ТЭЖЭЭЛ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ОЛГОХООР БОЛЖ ИРГЭДЭД ОЛГОХ
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ**




Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор сумын онцгой комисс хуралдаж нийт малчин өрхийн хооронд дальпуу татах ажлыг 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж ажиллаа





Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор сумын онцгой комиссоос иргэн Д.Цогтсайхантай хамтран ажиллаж ковшоор айлуудын хооронд зам татах өвөлжөөг түрэх ажлыг 02 дугаар сарын 19-ны өдрөөс 02 дугаар сарын 22-ны өдөр хүртэл зохион байгуулж ажиллаа






Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор / БИГОМ ЧОЙР ХХК /-аас 60 ковшоор 2 ажилтны хамт зам гаргах, өвөлжөө хаваржаа түрэх, худаг гаргах ажилд нийгмийн хариуцлагын хүрээнд ажиллуулж сумын онцгой комиссоос ажлын хэсэг гарж 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд нийт 27 айлд очиж ажиллаа





2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд
нийт 27 айлд очиж ажилласан маршрут



Сумын онцгой комисст 01 дүгээр сарын 09-ны өдөр ирсэн дуудлагын дагуу малтайгаа алга болсон 2 иргэнийг эрэн хайх ажлыг зохион байгуулж ажиллаа




2024.02.17-ны өдрийн цасан шуурганаар ирсэн цасанд хүн төөрсөн гэх дуудлагын дагуу шуурхай ажил зохион байгуулж олсон.



2024.02.22-ны өдөр Улсын онцгой комисс болон аймгийн онцгой комиссоос өвс тэжээл татан авч иргэдэд тараах ажлыг зохион байгуулав малчин өрхөд 8 боодол өвс, 4 боодол тэжээл, мал бүхий өрхөд 4 боодол өвс 2 боодол тэжээлийг тараав



2024.03.11-ны өдөр Аймгийн онцгой комиссоос нийт 930кг гурил, 465кг будаа татан авч иргэдэд тараах ажлыг зохион байгуулав малчин өрхөд 10кг гурил, 5 кг будаа тараав



Онцгой байдлын ерөнхий газрын хурандаа Л. Тамир, ахлуулсан ажлын хэсэг Баянтал суманд ажиллаж сумын Онцгой комиссоос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээ, тайланг сонслоо. Мөн хүнсний болон эмийн багцуудыг нэр бүхий малчдад хүргэж өгч цас зудын байдалтай газар дээр нь танилцаад явжээ



ОХУ-н тусламжаар ирсэн 25 тонн тэжээлийн арвайн будааг савлаж зөөвөрлөх тэжээлийн арвайн будааг малчин, мал бүхий өрхөд 5 шуудай будааг тараах ажлыг зохион байгуулж ажиллаа



Сэг зэмийн ажил эхэлсэнээс хойш хийж хэрэгжүүлсэн нийт гарсан ажлын зардал

Огноо	Техник, хүч	Ажлын хөлс	Км	Түлш шатахуун литр	Түлш шатахуун зардал	Сэг зэмийн Тн	Хийгдсэн ажил	Хүн хүч	Хоолны зардал	Бусад зардал томилолт
2024.03.17-04.12 23 өдөр	Ковш40	3,500,000	6,274	2,215	8,105,600	504	Сэг зэм хамах түүх Сэг зэм булшлах	Дунджаар өдөрт 8 хүн	650,000	5,610,000
	Ковш 60									
	Ачааны машин Кама									
	Ачааны машин Норд									
	Fielder									
	Приус 20									
	Прадо150									
	Ажлын хувцас хэрэгсэл	1,500,000								
	Экскаватор	15,000,000								
	НИЙТ	20,000,000								
								НИЙТ ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ		34,365,600

Сэг зэмийн ажилд нийт 2024.03.17-04.18 өдөр ажилласан өдөр өдрийн тайлан

№	Огноо	Техник	Км	Түлш шатахуун	Түлш шатахуун зардал	Сэг зэмийн Тн	Маршрут	Хүн хүч	Ажилд гарсан цаг	Ажлаас буусан цаг	Бусад зардал
1	2024.03.17	Ковш	62	35	133,000	30	16-р зөрлөг	Цогтсайхан	10.00	20.00	30,000
2		Ачааны машин Кама	62	40	152,000		621	Г.Ганзориг	10.00	20.00	30,000
3		Fielder	62	10	26,000		Сумын төв	Ш.Шинэбаяр	10.00	20.00	30,000
4								Т.Хишигням	10.00	20.00	30,000
5								Э.Түмэн-Эрдэнэ	10.00	20.00	30,000
6								Ш.Шинэбаяр	10.00	20.00	30,000
7								Г.Ганзориг	10.00	20.00	30,000
8								А.Баярбат	10.00	20.00	30,000
9								О.Бадамдорж	10.00	20.00	30,000
			НИЙТ	186	85		311,000	30			
1	2024.04.18	Ковш	112	35	133,000	16	14-р зөрлөг	Ц.Болдбаатар	9.00	20.00	30,000
2		Ачааны машин Кама	112	40	152,000		16-р зөрлөг	Цогтсайхан	9.00	20.00	30,000
3								Т.Хишигням	9.00	20.00	30,000
4								Э.Түмэн-Эрдэнэ	9.00	20.00	30,000
5								Ш.Шинэбаяр	9.00	20.00	30,000
6		Fielder	112	10	26,000		621	Г.Ганзориг	9.00	20.00	30,000
7								Ц.Золбаяр	9.00	20.00	30,000
8								О.Бадамдорж	9.00	20.00	30,000
			НИЙТ	336	85		311,000	16			

**#ХАМЖИХГҮЙ БОЛ #АМЖИХГҮЙ СЭГ ЗЭМ БӨӨГНҮҮЛЭХ АЖИЛ НИЙТ 504ТН СЭГ ЗЭМ
БӨӨГНҮҮЛСЭН**



**#ХАМЖИХГҮЙ БОЛ #АМЖИХГҮЙ СЭГ ЗЭМ БУЛШЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД НИЙТ 6 НҮХ
УХСАН БАЙНА**



**#ХАМЖИХГҮЙ БОЛ #АМЖИХГҮЙ СЭГ ЗЭМ БУЛШЛАХАД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛЭГИЙН
ГАЗАРТАЙ ХАМТРАН АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ ХИЙЖ УСТГАВ.**




Нохой муур устгал

- ▶ Иргэн Б.Будтай нохой муур устгалын гэрээ байгуулан 2024 оны устгалын ажлыг хийлээ.
- ▶ Үүнд: Хяналтаар цагдаагийн машин, муур нохой ачих хогийн машин, устгалын машин, засаг даргын тамгын газрын машин гээд нийт 4 машинд 40 литр бинзен 30 литр түлш зарцуулан устгалыг Лүн баг, төв хогийн цэг 18,6.21,16,14 дүгээр зөрлөг, Их-Уул багийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамруулан ажиллаа. 2024 он гарсаар нийт 3 удаа 156 нохой, 25 муур устгалын ажил хийгдэж дууссан.



**2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын аюулгүй нөөцөд 1475 боодол
өвс татан авч буулгалаа.
Мөн ногоон тэжээл 590 бооплыг захиалсан байна.**



2024 оны 11 сарын 14-нд Баянтал суманд гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, дадлага сургуулилт боллоо.

Онцгой байдлын ерөнхий газраас ирсэн ажлын хэсэг “Хангалттай” гэсэн үнэлэлт дүгнэлт өгсөн.



2024 оны 2 дугаар ээлжийн цэрэг татлага

- 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “Цэргийн жинхэнэ албаны 2 дугаар ээлжийн цэрэг татлага” сумын иргэний танхимд зохион байгуулагдлаа. Цэрэг татлагат аймгийн Цэргийн штаб, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сумын Эрүүл Мэндийн Төвийн мэргэжлийн эмч нар, цэргийн татлагыг зохион байгуулах сумын ажлын хэсэг ажилласан. Нийт 2 багийн цэргийн албанд татагдах 32 иргэд байх бөгөөд үүнээс гадаадад оршин суудаг, оюутан, ажил эрхэлж байгаа, эрүүл мэндийн шалтгаанаар цэргийн алба хаах боломжгүй иргэд хасагдаж, үзлэгээр 14 хүн хамрагдаж үүнээс 2 хүн цэргийн алба хаахаар болсон.



► **Зам дагуух ажлын явц**

- Сумын Засмал замын ажил гүйцэтгэсэн “Аасгалдай ХХК-тай ярилцаж үерийн улмаас замын хөвөө налсан хэсгийг янзлуулж, замын тэмдэг тэмдэглэгээг хийлгэж ажиллаа.



▶ Мэдээлэл сургалт

- Тус суманд Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас иргэд эцэг эхчүүдэд хүүхэд хамгааллын тухай хуульд орсон өөрчлөлт, цаашид анхаарвал зохих асуудлуудын талаар мэдээлэл өгч ажилласан.



Сумын e-mongolia цахим системээс 2024 оны 10-р сарын 21-ны өдрийн байдлаар нийт 269 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна.

Үүнд:

- ❖ Иргэний үнэмлэхийн лавлагаа – 12
- ❖ Оршин суугаа хаягын тодорхойлолт - 12
- ❖ Үл хөдлөх хөрөнгөний лавлагаа – 1
- ❖ Гэрлэсний бүртгэлийн лавлагаа – 4
- ❖ Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа - 1
- ❖ Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа – 9
- ❖ Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт – 7
- ❖ Мал тооллогын лавлагаа – 5
- ❖ Малчны тодорхойлолт – 3
- ❖ Багийн хэмжээнд давхардсан тоогоор 215 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна.

2024-2025 оны хөдөө, төв суурийн газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг сумын орлогч даргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, сумын өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг батлуулан ажилласан.

2024 оны 10 сарын 21-ны байлаар Малчин өрхийн түвшинд 585 тн өвс, 32,5 тн ногоон тэжээл, 6,2 тн гар тэжээл бэлтгэсэн байна.



2024.11.15-НЫ БАЯНТАЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛЖ ЭЛЧ ТӨЛӨӨЛӨГЧ ТОДОРХОЙЛЛО.



2025 оны хаврын их бүтээн байгуулалтын ажил байрнуудын дундах авто зам, дугуйн болон явган хүний замуудын бэлтгэл ажлын нэг болох бордюр 2024 оны 23-нд хүлээж авсан.



Сумын засмал замын хурд сааруулагчийг будаж тодруулан тойрогт чиг заасан тэмдэгүүдийг байршуулсан.



Төрийн албан хаагчийн манлайлал ёс зүн сургалт 2024 оны 11 сарын 12-13-ны өдрүүдэд ЗДТГ-ын ажилчин албан хаагч нар хамрагдлаа.



2024 оны 11 сарын 9, 10-ны өдрүүдэд Баянтал сумын иргэдийн Төлөөлөгчид, Засаг даргын нэрэмжит спортын арга хэмжээ зохион байгуулсан.



Аймгийн татварын хэлтсийнхэн , багийн Засаг дарга, цагдаа хамтарсан ажлын хэсэг хөдөөгүүр ажиллаж,
2023 оны татвар, малчдын өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцах, цагдаагийн зүгээс анхаарах, сэрэмжлүүлэх мэдээлэл зэргийг хүргэж байна



Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг сар бүр тогтмолжуулан ажиллаж байна.



- Аймгийн ХБИ- ийн дунд зохион байгуулж буй спортын тэмцээнд Баянтал сумын баг тамирчид амжилттай оролцож.
- Дартс Д.Намжил 1-р байр,суугаа волейбол 1,2-р байр,гар барилдаан Н.Ариунболд 2-р байр ,Ц.Болдбаатар 3-р байр тус тус амжилт үзүүлсэн.



Сумын Засаг даргаас анх удаа сум орон нутагтаа төрж өссөн, одоо оюутан болж суралцаж байгаа 5 залуучуудад “Сумын Засаг даргын тэтгэлэг 1,0 сая төгрөг”-ийн батламжийг гардуулан өгч сурлагын өндөр амжилт хүслээ.



Сумын төв шинээр цамхаг гэрэлтүүлэг 4 ширхэгийг хийж гүйцэтгэсэн.

- ОНХСангийн хөрөнгөөр 7,050,000 сая төгрөгөөр 2 ширхэг гэрэлтэй цамхаг 2 ширхэг.
- Засаг даргын нөөц хөрөнгө болох 10,000,000 сая төгрөгөөр 4 ширхэг гэрэлтэй 2 цамхаг гэрэл тус тус хийсэн.





Төрийн үйлчилгээг багийн иргэдэд хүргэх, мэдээллээр хангах, санал хүсэлтийг сонсох зорилгоор Багийн иргэдийн нийтийн хурлыг тогтсон хугацаанд хийж гүйцэтгэж байна. Мөн багийн өдөрлөгөөр олон төрөлт тэмцээн уралдааныг тогмолжуулан ажиллаж байна.





Баянтал сумын Лүн багийн 2024 онд хийсэн ажлын тайлан.

